

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2024 он	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:erdeneb@audit.gov.mn">erdeneb@audit.gov.mn</a> Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a> “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн Утас: 99030170 Цахим хаяг: <a href="mailto:dalaivan.orkhon@gmail.com">dalaivan.orkhon@gmail.com</a> “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99921600 Цахим хаяг: <a href="mailto:dalaivan.orkhon@gmail.com">dalaivan.orkhon@gmail.com</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 187

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.БААСАНСҮРЭН ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн ба улсын төсвөөс 512,771.0 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 68,150.8 мянган төгрөгийн нийт 584,816.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх онтой харьцуулахад 168,154.0 төгрөгөөр буюу 29 хувиар өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 62,525.3 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

#### Аудитын гол асуудал

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжүүлэх болсноор сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 7 болж зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний

006020430

бусад зардлаас зарцуулах болсон байна.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг арван зорилтын хүрээнд дөчин долоон арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 97.5 хувийн биелэлтэйгээр дүгнэгдсэн байна.

Тус цэцэрлэг нь тайлангийн хугацааны эцэст бараа материалын дансанд 8,840.0 мянган төгрөгийн хоол хүнсний материал үлдэгдэлтэй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

2023 онд нүүдлийн гэр цэцэрлэгийн арга хэмжээний хүрээнд хамран сургах тойргийн 2-5 насны 855 хүүхдийг 22 хоногийн хугацаанд хамруулахад 10,922.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,848,452.24	123,726,167.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,473,013.00	74,998,400.82
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	12,473,013.00	74,998,400.82
31210	Төгрөг	12,473,013.00	74,998,400.82
31211	Төрийн сангийн харилцах	12,473,013.00	74,998,400.82
35	БАРАА МАТЕРИАЛ	58,375,439.24	48,727,766.24
35100	Түүхий эд материал	11,709,400.00	0
35110	Тусгай зориулалттай материал	11,709,400.00	0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,153,962.24	18,876,225.24
35400	Хангамжийн материал	34,512,077.00	29,851,541.00
35410	Бичиг хэргийн материал	0	37,400.00
35420	Аж ахуйн материал	25,159,687.00	20,974,100.00
35460	Хүнсний материал	9,352,390.00	8,840,041.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	807,090,599.46	791,798,644.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	807,090,599.46	791,798,644.47
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	794,829,599.46	779,875,144.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,135,331,392.32	1,135,331,392.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-412,808,676.51	-435,716,289.27
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	57,394,920.00	51,990,420.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,056,079.19	-16,486,242.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,088,287.00	54,006,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,542,745.16	-11,426,796.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	0	1,355,000.00
39217	Ном	3,422,501.00	821,360.00
39300	Биет бус хөрөнгө	12,261,000.00	11,923,500.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-675,000.00	-1,012,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,586,000.00	11,586,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	877,939,051.70	915,524,811.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	2,260,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	2,260,000.00
41300	Өглөг	0	2,260,000.00
41360	Бусад өглөг	0	2,260,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	2,260,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	877,939,051.70	913,264,811.53
51	Засгийн газрын хувь оролцоо	877,939,051.70	913,264,811.53
51100	Засгийн газрын оруулсан капитал	118,320,473.00	118,320,473.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	118,320,473.00	118,320,473.00
51200	Хуримтлагдсан үр дүн	435,704,334.84	471,030,094.67
51210	Өмнөх үеийн үр дүн	-449,968,216.86	435,704,334.84
51220	Тайлант үеийн үр дүн	885,672,551.70	35,325,759.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	323,914,243.86	323,914,243.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	877,939,051.70	915,524,811.53

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	821,109,701.00	606,095,757.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	393,601,901.00	25,173,957.00

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	393,601,901.00	25,173,957.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	393,601,901.00	25,173,957.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	393,601,901.00	25,173,957.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,507,800.00	580,921,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	361,626,200.00	512,771,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	361,626,200.00	512,771,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,881,600.00	68,150,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,881,600.00	68,150,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	442,947,814.98	567,948,848.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,947,814.98	567,948,848.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,947,670.27	564,350,094.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,678,512.00	341,033,306.00
210101	Үндсэн цалин	210,223,597.00	241,207,533.00
210102	Нэмэгдэл	53,834,483.00	83,717,329.00
210104	Урамшуулал	12,620,432.00	16,108,444.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,761,669.29	43,481,603.17
210201	Тэтгэврийн даатгал	23,752,640.37	29,879,781.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,777,632.42	3,461,091.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,222,126.33	2,627,799.00
210204	Ажилгүйдлийн даатгал	536,911.09	673,030.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,472,359.08	6,839,902.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,717,913.00	66,423,845.60
210301	Гэрэл, цахилгаан	4,799,849.00	9,073,109.60
210302	Түлш, халаалт	47,838,064.00	56,990,736.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,891,291.64	
210401	Бичиг хэрэг	114,200.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	530,280.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,246,811.64	
2105	Нормативт зардал	30,299,268.00	43,315,019.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	228,700.00	
210502	Хоол, хүнс	28,340,568.00	43,315,019.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,730,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,800.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,200,800.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	877,300.00	883,333.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	877,300.00	883,333.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,520,916.34	68,212,987.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,740,510.00	26,490,981.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,881,400.00	3,580,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,899,006.34	38,141,806.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144.71	3,598,754.40
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,871,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,871,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	144.71	726,954.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	144.71	726,954.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	378,161,886.02	38,146,908.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,821,148.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		2,821,148.60

IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-2,821,148.60
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	378,161,886.02	35,325,759.83

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	427,507,800.00	580,921,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,507,800.00	580,921,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	361,626,200.00	512,771,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	361,626,200.00	512,771,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,881,600.00	68,150,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,881,600.00	68,150,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	415,034,787.00	517,482,412.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,034,787.00	517,482,412.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	415,034,642.29	513,883,657.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,678,512.00	341,033,306.00
210101	Үндсэн цалин	210,223,597.00	241,207,533.00
210102	Нэмэгдэл	53,834,483.00	83,717,329.00
210104	Урамшуулал	12,620,432.00	16,108,444.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,761,669.29	43,481,603.17
210201	Тэтгэврийн даатгал	23,752,640.37	29,879,781.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,777,632.42	3,461,091.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,222,126.33	2,627,799.00
210204	Ажилгүйдлийн даатгал	536,911.09	673,030.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,472,359.08	6,839,902.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,643,913.00	66,423,845.60
210301	Гэрэл, цахилгаан	4,799,849.00	9,073,109.60
210302	Түлш, халаалт	46,484,064.00	56,990,736.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	602,280.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	602,280.00	
2105	Норматив зардал	36,658,568.00	42,802,670.00
210502	Хоол, хүнс	36,658,568.00	42,802,670.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	883,333.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	883,333.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,875,700.00	18,258,900.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,975,700.00	15,616,700.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,900,000.00	2,642,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144.71	3,598,754.40
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,871,800.00

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,871,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	144.71	726,954.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	144.71	726,954.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,473,013.00	63,439,387.82
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		914,000.00
	Дотоод эх үүсвэрээр		914,000.00
223001	Бусад хөрөнгө		914,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-914,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,473,013.00	62,525,387.82
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		12,473,013.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		74,998,400.82

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	118,320,473.00	323,914,243.86	57,542,448.82	499,777,165.68
7	Тайлант үеийн үр дүн			378,161,886.02	378,161,886.02
10	2022 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	118,320,473.00	323,914,243.86	435,704,334.84	877,939,051.70
17	Тайлант үеийн үр дүн			35,325,759.83	35,325,759.83
19	2023 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	118,320,473.00	323,914,243.86	471,030,094.67	913,264,811.53

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
<b>71801 - СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ</b>					
<b>80111 - ТӨРИЙН ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТМОЛ ЗАРДАЛ</b>					
<b>1220</b>	Тусламжийн орлого		68,150,800.00	(68,150,800.00)	
122005	Төсвөөс санхүүжих		68,150,800.00	(68,150,800.00)	
<b>2103</b>	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,150,800.00	66,423,845.60	726,954.40	98.92
210301	Гэрэл, цахилгаан	9,800,000.00	9,073,109.60	726,890.40	92.58
210302	Түлш, халаалт	56,990,800.00	56,990,736.00	64.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	360,000.00		100.00
<b>2106</b>	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00		100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00		100.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		726,954.40	(726,954.40)	
<b>81605 - ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ</b>					
<b>1220</b>	Тусламжийн орлого		1,325,500.00	(1,325,500.00)	
122005	Төсвөөс санхүүжих		1,325,500.00	(1,325,500.00)	

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	1,325,500.00	1,325,000.01	499.99	99.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,325,500.00	1,325,000.01	499.99	99.96
<b>81807 - ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ</b>					
<b>1220</b>	Тусламжийн орлого		46,638,800.00	(46,638,800.00)	
122005	Төсвөөс санхүүжих		46,638,800.00	(46,638,800.00)	
<b>2105</b>	Норматив зардал	52,049,400.00	41,542,070.00	10,507,330.00	79.81
210502	Хоол, хүнс	52,049,400.00	41,542,070.00	10,507,330.00	79.81
<b>81816 - ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР</b>					
<b>1220</b>	Тусламжийн орлого		3,442,200.00	(3,442,200.00)	
122005	Төсвөөс санхүүжих		3,442,200.00	(3,442,200.00)	
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	3,442,200.00	3,442,200.00		100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,442,200.00	3,442,200.00		100.00
<b>81823 - БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ АЖИЛЧДЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ</b>					
<b>1220</b>	Тусламжийн орлого		1,325,500.00	(1,325,500.00)	
122005	Төсвөөс санхүүжих		1,325,500.00	(1,325,500.00)	
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	1,325,500.00	1,325,500.00		100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,325,500.00	1,325,500.00		100.00
<b>81832 - НҮҮДЛИЙН БҮЛЭГТ ХАМРУУЛАХ</b>					
<b>1220</b>	Тусламжийн орлого		16,005,600.00	(16,005,600.00)	
122005	Төсвөөс санхүүжих		16,005,600.00	(16,005,600.00)	
<b>2101</b>	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,825,200.00	5,376,633.00	2,448,567.00	68.71
210101	Үндсэн цалин	6,180,000.00	3,731,433.00	2,448,567.00	60.38
210102	Нэмэгдэл	1,645,200.00	1,645,200.00		100.00
<b>2102</b>	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	978,200.00	978,200.00		100.00
210201	Тэтгэврийн даатгал	665,100.00	665,100.00		100.00
210202	Тэтгэмжийн даатгал	78,300.00	78,300.00		100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	62,600.00	62,600.00		100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	15,700.00	15,700.00		100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	156,500.00	156,500.00		100.00
<b>2105</b>	Норматив зардал	4,989,600.00	1,260,600.00	3,729,000.00	25.26
210502	Хоол, хүнс	4,989,600.00	1,260,600.00	3,729,000.00	25.26
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	2,212,600.00	2,212,600.00		100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,212,600.00	2,212,600.00		100.00
<b>81834 - БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>					
<b>1220</b>	Тусламжийн орлого		360,114,900.00	(360,114,900.00)	
122005	Төсвөөс санхүүжих		360,114,900.00	(360,114,900.00)	
<b>2101</b>	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313,085,900.00	269,936,206.00	43,149,694.00	86.22
210101	Үндсэн цалин	207,726,900.00	195,381,188.00	12,345,712.00	94.06
210102	Нэмэгдэл	101,804,200.00	63,681,899.00	38,122,301.00	62.55
210104	Урамшуулал	3,554,800.00	10,873,119.00	(7,318,319.00)	305.87
<b>2102</b>	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,012,700.00	34,972,916.17	5,039,783.83	87.40

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

210201	Тэтгэврийн даатгал	27,207,700.00	24,058,760.00	3,148,940.00	88.43
210202	Тэтгэмжийн даатгал	3,201,600.00	2,783,318.17	418,281.83	86.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,560,700.00	2,093,079.00	467,621.00	81.74
210204	Ажилгүйдлийн даатгал	640,400.00	542,835.00	97,565.00	84.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6,402,300.00	5,494,924.00	907,376.00	85.83
<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	883,600.00	883,333.00	267.00	99.97
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	883,600.00	883,333.00	267.00	99.97
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	9,351,500.00	9,321,200.00	30,300.00	99.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,700,600.00	6,679,000.00	21,600.00	99.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,650,900.00	2,642,200.00	8,700.00	99.67
<b>81835 - СУРГАЛТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ</b>					
<b>1220</b>	Тусламжийн орлого		83,918,500.00	(83,918,500.00)	
122005	Төсвөөс санхүүжих		83,918,500.00	(83,918,500.00)	
<b>2101</b>	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,550,300.00	65,720,467.00	8,829,833.00	88.16
210101	Үндсэн цалин	44,045,000.00	42,094,912.00	1,950,088.00	95.57
210102	Нэмэгдэл	25,256,000.00	18,390,230.00	6,865,770.00	72.82
210104	Урамшуулал	5,249,300.00	5,235,325.00	13,975.00	99.73
<b>2102</b>	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,793,600.00	7,530,487.00	1,263,113.00	85.64
210201	Тэтгэврийн даатгал	5,979,400.00	5,155,921.00	823,479.00	86.23
210202	Тэтгэмжийн даатгал	703,500.00	599,473.00	104,027.00	85.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	562,900.00	472,120.00	90,780.00	83.87
210204	Ажилгүйдлийн даатгал	140,900.00	114,495.00	26,405.00	81.26
210205	Эрүүл мэндийн даатгал	1,406,900.00	1,188,478.00	218,422.00	84.47
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	1,546,400.00	1,546,400.00		100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,546,400.00	1,546,400.00		100.00
<b>2132</b>	Бусад урсгал шилжүүлэг	2,871,800.00	2,871,800.00		100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,871,800.00	2,871,800.00		100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			12,473,013.00	(12,473,013.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			74,998,400.82	(74,998,400.82)	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,533.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> зөрчил<sup>2</sup> илэрснээс, 6,795.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 53.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,685.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

#### Залруулсан алдаа:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тайланд онд 1,365.0 мянган төгрөгийн 5 ханатай гэрийг дахин үнэлж бүртгэлд тусгахдаа өрх, хана, унь гэх мэтчилэн салгаж тавилга эд хогшлын дансанд бүртгэсэн, 5,000.0 мянган төгрөгийн нам даралтын тогоо, 440.0 мянган төгрөгийн худгийн насос зэргийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2008 оны 388 дугаар тушаалын 2-р хавсралт заасан хөрөнгийн ангиллыг зөрчиж байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын явцад залруулах санал тавьж залруулсан болно.

### **3.1 Төлбөрийн акт**

Шатахууны тооцооллыг шалгахад норм нормативыг хэтрүүлэн 53.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Зам тээвэр хөгжлийн Сайдын 2019 оны 390 тушаалаар батлагдсан *“Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”*-ыг баримталж ажиллаагүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй байна.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Ажил хавсран гүйцэтгэж буй ажилтны цалинг тооцоолохдоо хавсран ажиллаж буй албан тушаалын цалингаар бус өөрийн үндсэн ажлын цалингаар тооцон 89.3 мянган төгрөг илүү олгосон байна. Э

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1.-д *“Ажил олгогч нь ажилтантай тохиролцооноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно.”*, 56.2.-д *“Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно”*. гэсэн заалтыг зөрчсөн байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах,

#### **2. Өглөг, авлагын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Тайлангийн хугацааны эцэст 2,260.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д *“Төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх”* гэсэн заалт зөрчигдөж байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах.

#### **3. Зардлын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн тайлангийн хугацааны батлагдсан төсвийн цалингийн зардлаас 426.6 мянган төгрөгийг, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 53.3 мянган төгрөгийг, хоолны материалын зардлаас 856.1 мянган төгрөгийг нүүдлийн гэр цэцэрлэгийн хөтөлбөр арга хэмжээний цалин, нийгмийн даатгал, хоолны материалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2.-д “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах,” 41.2.3.-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах,” 42.3.1.-д “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх,” зэрэг хуулийн заалтуудыг зөрчсөн байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахад анхаарч ажиллах, хөтөлбөр арга хэмжээний зардал хэмнэгдэх эсвэл дутагдсан тохиолдолд дээд шатны байгууллагад мэдэгдэж тухай бүрд нь төсвийн хуваарь өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж ажиллах

#### **4. Бараа материалын данстай холбоотой**

**Илрүүлэлт:** Тайлангийн хугацаанд эцэг эх, асран хамгаалагчаас авч хэрэглэдэг сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг үнэ төлбөргүй орлогод бүртгээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д “Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ”, Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 1/4511 тушаалын хавсралтын улирал бүр тайлагнах гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

##### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой	1	6,795.0					1	6,795.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>6,795.0</b>					<b>1</b>	<b>6,795.0</b>				

##### **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн тооцоололтой холбоотой	1	89.2					1	89.2				
Өглөг авлагатай холбоотой	1	2,260.0					1	2,260.0				
Зардлын гүйлгээтэй холбоотой	1	1,336.0					1	1,336.0				
Шатахуун зарцуулалттай холбоотой	1	53.5	1	53.5								
Бараа материалтай холбоотой	1						1					
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>3,738.8</b>	<b>1</b>	<b>53.5</b>			<b>4</b>	<b>3,685.3</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			